**ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН 2023 ОНЫ ХӨГЖЛИЙН**
**ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН НЭГТГЭЛ**

**2023.06.15** **Жавхлант**

| № | Салбар | Зорилтын гарчиг | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | 100 % | 90 % | 70 % | 50 % | 30 % | 0 % | Хугацаа болоогүй | % |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО | 1.1. Эрүүл мэнд | 4 | 14 | 4 | | 7 | 2 | - | - | 1 | 76.1 |
| | | 1.2. Биеийн тамир, спорт | 1 | 6 | 3 | - | 2 | - | - | - | 1 | 88 |
| | | 1.3. Боловсрол | 2 | 18 | 11 | - | 5 | - | 2 | - | - | 83.6 |
| | | 1.4. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал | 3 | 13 | 9 | 1 | 1 | 1 | 1 | - | - | 87.7 |
| | | 1.5. Үндэсний бахархал, өв соёл | 5 | 12 | 4 | 5 | - | 1 | - | - | 2 | 90 |
| 2. | ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | 2.1. Эдийн засаг, төсөв санхүү | 2 | 8 | 2 | - | 6 | - | - | - | - | 77.5 |
| 3. | ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО | 3.1. Газар тариалангийн үйлдвэрлэл | 1 | 12 | 1 | 3 | 5 | - | 3 | - | - | 67.5 |
| | | 3.2. Мал аж ахуйн үйлдвэр | 2 | 13 | 1 | 1 | 3 | 6 | 1 | 1 | - | 56.1 |
| | | 3.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ | 1 | 6 | - | - | 1 | 5 | - | - | - | 53.3 |
| 4. | НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | 4.1. Ногоон хөгжил | 2 | 12 | - | - | 9 | - | 3 | - | - | 60 |
| | | 4.2. Уул уурхай | 1 | 3 | - | - | 3 | - | - | - | - | 70 |
| 5. | ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | 5.1. Сумын төвийн тохижилт, шинэчлэл | 1 | 9 | - | - | 2 | 6 | - | - | 1 | 55 |
| | | 5.2. Орон сууц, нийтийн аж ахуй | 1 | 2 | - | - | 1 | 1 | - | - | - | 60 |
| | | 5.3. Зам тээвэр, харилцаа холбоо | 1 | 1 | - | - | - | 1 | - | - | - | 50 |
| | | 5.4. Газрын харилцаа | 1 | 6 | 1 | - | - | 3 | 2 | - | - | 51.6 |
| 6. | ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | 6.1. “Цахим Төв аймаг” төрийн үйлчилгээ | 3 | 10 | 2 | 3 | 4 | - | - | - | 1 | 83.3 |
| | | 6.2. Мэргэшсэн , хариуцлагатай төрийн алба | 3 | 8 | 2 | 4 | 2 | - | - | - | - | 87.5 |
| | | 6.3. Амар тайван, аюулгүй нийгэм | 2 | 7 | | 3 | 2 | 2 | | - | | 72.8 |
| | | 6.4. Батлан хамгаалах | 1 | 1 | 1 | - | - | - | - | - | - | 100 |
| 7 | **Нийт** | | **37** | **161** | **41** | **20** | **53** | **28** | **12** | **1** | **6** | **73,3%** |

**ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА ....................... Д.БАТБИЛЭГ**

**НЭГТГЭСЭН: ЗДОрлогч ...................... Б.БЯМБАЦОГТ**

**ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

| № | Зорилт | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин, үр дүн | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулан, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай иргэнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| **1.1. Эрүүл мэнд** | | | | | | |
| **1.** | **Өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээ хэрэгжүүлнэ.** | 1. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмолжуулна. | Сургалтад хамрагдсан хүний тоо | 411 | 675 | Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдол, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн төвийн фэйсбүүк хуудас болон Page хуудсанд 32 нэр төрлийн мэдээ, мэдээлэл, брошур видео бичлэг зэргийг 14 хоног тутам шинэчлэн байршуулан ажилласан. Хандалтын тоо-11136<br><br>Хэрэгжилт-70% |
| | | 2. Осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлийг бууруулах нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, хүүхдийн осол гэмтлийн шалтгаант нас баралтыг бууруулна. | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар | 70% | 100% | Осол гэмтлээс сэргийлэх өдөр-ийн хүрээнд “Аюулгүй бай-Эрүүл бай” сэдэвт унаж, бэртэхээс урьдчилан сэргийлэх аяны хүрээнд 5 албан байгууллага, 3 АНН, айл өрхүүдэд өөрийн эзэмшлийн талбайгаас гадна 50м хүртэлх талбайн мөс хүргэн гадна талбайн цас, мөсөө цэвэрлэх халтирч унаж болзошгүй газруудад шороо цацах, эрсдэлээс сэргийлэх зөвлөмжийг хүргэн ажилласан.<br>Эмнэлгийн фэйсбүүк хуудас болон зурагт, вэб сайт, сумын группүүдээр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дамжуулан 5 төрлийн анхааруулга, санамж зөвлөмжийг байршуулан ажилласан. Хандалт-786<br>4 удааагийн сургалтаар 47 хэвтэн эмчлүүлэгчдэд сургалт хийсэн.<br>Баяр ёслолын өдрүүдэд Осол гэмтэл, хөлдөлтөөс сэргийлж Сумын засаг даргын захирамжийн дагуу Албан байгууллагын ажилчид хуваарийн дагуу 24 цагийн хариуцлагатай жижүүр хийж ажилласан.<br>Хэрэгжилт-70% |
| | | 3. Хавдрын эсрэг “Эрүүл Төв аймаг” хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувиар | 70% | 85% | Хавдрын эсрэг Эрүүл Төв аймаг хөтөлбөрийн хүрээнд 25 хүнд элэгний B, C вирус илрүүлэх шинжилгээ хийж шинээр 1 тохиолдлыг илрүүлэн вирусын ачаалал тоолох шинжилгээнд илгээсэн. Мөн умайн хүзүүний эсийн 26 эмэгтэй хамруулсан. Эсийн шинжилгээнд өөрчлөлттэй гарсан 2 эмэгтэйг лавлагаа шатлалд илгээн эмчлүүлсэн.<br>Хэрэгжилт-50% |
| | | 4. Эрт илрүүлэг үзлэгээр шүдний цоорол өвчнөөр оношлогдсон 0-18 насны хүүхдүүдийг эмчлэн эрүүлжүүлнэ. | Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо | 411 | 450 | **0-17** насны хүүхдийн өвчлөлийг илрүүлэх үзлэгт 626 хүүхэд хамрагдахаас 515 хүүхэд хамрагдсан. Илрүүлэг үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн 80 орчим хувь нь шүдний өвчлөлтэй байна. Хүүхдийн шүдний өвчлөлийг бууруулах үүднээс Нью дент шүдний эмнэлэгтэй хамтран 7 хоног бүр эмчилгээ хийж байна. Мөн Гэр бүл эмнэлэгтэй хамтран 56 хүүхдийг шүдний эмчилгээнд хамруулсан. АНЭ-ийн нүүдлийн амбулаторийн үзлэгт 18 хүүхдийн шүдний өвчлөлийг эмчилсэн.<br>Хэрэгжилт-70% |
| | | | Эмчлэн эрүүлжсэн хувь | 50% | 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 5. Нийгмийн салбарын “Явуулын үйлчилгээ”-нд сумын иргэдийг хамруулна. | Явуулын үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоогоор | 150 | 350 | Он гарснаар 1,2 дугаар багийн айлуудаар 2 удаагийн бүтэн тойролт хийж нийт 155 иргэнд эрүүл мэндийн анхан шатны үзлэг хийж зөвлөгөө өгсөн. Хэрэгжилт-70% |
| | | 6. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийн хамралтыг нэмэгдүүлнэ | Хамралтын дундаж хувиар | Артерийн гипертензи 95% | 99% | Артерийн гипертензийн илрүүлэг үзлэгт 1080 иргэн хамрагдахаас 466 иргэн хамрагдаж 43 хувьтай. Чихрийн шижингийн илрүүлэг үзлэгт 700 иргэн хамрагдахаас 332 иргэн хамрагдаж 47 хувь. Хөхний үзлэгт 368 эмэгтэй хамрагдахаас 158 эмэгтэй хамрагдаж 42,9%-тай. Умайн хүзүүний хавдар илрүүлэх үзлэгт 87 эмэгтэй хамрагдахаас 26 эмэгтэй хамрагдаж 29,8%-тай. Хэрэгжилт-50% |
| | | | | Чихрийн шижин 95% | 99% | |
| | | | | Хөхний өмөн 100% | 100% | |
| | | | | Умайн хүзүүний өмөн 50% | 60% | |
| | | 7. Сумын хүн амд эрүүл мэндийн даатгалын анхан шатны багцын тусламж үйлчилгээг бүрэн үзүүлж, гүйцэтгэлийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ. | Гүйцэтгэлийн санхүүжилтийн хувиар | 90% | 95% | ЭМДЕГ-аас сумын эрүүл мэндийн төвийг нэг иргэнд ногдох зардлын аргаар санхүүжүүлдэг болсонтой холбоотойгоор нийт санхүүжилтийн 80%-ийг ЭМД-аас авч байна. Үлдсэн 20%-ийн санхүүжилтийг үндсэн 4 төрлийн тусламж үйлчилгээнээс авч байна. Эхний 5 сарын байдлаар 82,5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Хэрэгжилт-70% |
| | | 8. БЗДХ, сүрьеэ өвчний идэвхтэй илрүүлгийг нэмэгдүүлж, эмчлэн эрүүлжүүлнэ. | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдийн тоогоор | Сүрьеэ | 131 | АНЭ-ийн нүүдлийн амбулаторийн үзлэгээр бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг үзлэгт 51 иргэн, Сүрьеэгийн илрүүлэг үзлэгт 46 иргэнийг хамруулсан. Шинээр сэжигтэй болон батлагдсан тохиолдол гараагүй. Хэрэгжилт-70% |
| | | | | БЗДХ | 197 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **2.** | **Хүн амд нэн шаардлагатай, хүн төвтэй, стандартад нийцсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ.** | 9. “Эрүүл эхээс эрүүл хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд эх хүүхдийн эндэгдлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ. | Жирэмсний эрт хяналтын хувь | 100% | 100% | Он гарсанаас хойш шинээр 6 эхийг хяналтад авсан. Жирэмсний эрт үеийн хяналтын хувь 100%-тай.<br><br>Эх нярайн эндэгдэлгүй ажиллаж байна.<br><br>Хэрэгжилт-100% |
| | | | Ноцтой хүндрэлийн тохиолдлын тоо | - | - | |
| | | | Перинаталь эндэгдэл-1000 амьд төрөлтөд | - | - | |
| | | | 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл1000 амьд төрөлтөд | - | - | |
| | | 10. Стандартад нийцсэн уламжлалт анагаах ухааны кабинетийг өргөжүүлж, тохижуулна. | УАУ-ны кабинетийн тоо | 1 | 1 | Хугацаа болоогүй |
| | | 11. Эмийн худалдаа, үйлчилгээ эрхэлдэг өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг өндөржүүлж, эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг сайжруулна. | Эрүүл мэндийн санхүүжилтийг бүрэн авсан хувь | 98% | 100% | ЭМДЕГ Новартис хөтөлбөрийн хүрээнд зүрх судасны өвчин, чихрийн шижин өвчний үе хэрэглэх 7 нэр төрлийн эмийг 100% хөнгөлөлттэй олгож байна.<br><br>Хэрэгжилт-100% |
| **3.** | **Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.** | 12. Нэн шаардлагатай чиглэлээр эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн зэрэг хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлж сургах, чадавхжуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн хангалтын хувиар | 85% | 90% | Яаралтай тусламж, Халдварт бус өвчний хяналт, ХӨЦМ зэрэг сургалтуудад давхардсан тоогоор 12 эмч мэргэжилтэн хамрагдсан байна.<br><br>Хэрэгжилт-70% |
| | | 13. Эмч эмнэлгийн мэргэжилтний харилцаа, хандлага, ёс зүйг дээшлүүлэх аян зохион байгуулна. | Зохион байгуулсан аяны тоогоор | 1 | 1 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны 09-р сарын 04-ны өдрийн А/406 тоот тушаал Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм батлах тухай, Сэтгэлд нийцсэн 8 үйлчилгээ, байгууллагын хөгжил, соёл зэрэг сэдвүүдээр дотоодын сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 25 эмч, ажилчид хамрагдсан. Мөн Төв ДЗОУБ, ЗДТГ-аас зохион байгуулсан Хүүхэд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүмүүжүүлэх зэрэг арга, Харилцаа хандлага сэдэвт сургалтад 8 эмч, ажилчид хамрагдсан.<br><br>Хэрэгжилт-100% |
| **4.** | **Эрүүл мэндийн байгууллагын тоног төхөөрөмж, автомашин, барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандартын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.** | 14. Эрүүл мэндийн байгууллагын тоног, төхөөрөмжийн стандарт хангалтыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулна. | Тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 90% | 90% | Эрүүл мэндийн яам, Туваан сангийн дэмжлэгтэйгээр Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, дефиблятор, зөөврийн компьютер, дуслын памп Спирограммын аппаратуудаар хангагдсан.<br><br>Хэрэгжилт-100% |
| **1.2. Биеийн тамир, спорт** | | | | | | |
| **5.** | **Иргэн бүрийг идэвхтэй амьдралын дадал хэвшилд уриалан нийтийн биеийн тамир, их спортод ээлтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.** | 15. Нийтийн биеийн тамир, спортын чиглэлээр нийтийг хамарсан үйл ажиллагааг өргөжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо, оролцсон иргэд | 16 төрлийн спортын арга арга хэмжээнд 776 иргэн хамрагдсан | 22 арга хэмжээ зохион байгуулж 800 иргэнийг хамруулна. | 2023 оны эхни хагас жилийн байдлаар 11 удирдамжаар 13 төрлийн спортын арга хэмжээ зохион байгуулсан Гар бөмбөгийн тэмцээнд 262, сагсан бөмбөг 180, шатар 58, тенсс 72, шагайн харвaанд 98 бүгд 670 иргэн тус тус хамрагдсан байна .<br>Хэрэгжилт 100% |
| | | 16. Иргэдийг сорил судалгаанд хамруулан зохих түвшинд хүрсэн | Судалгаанд хамрагдсан иргэдийн тоо | ЕБС-308, СӨБ-120 хүүхэд, ЗДТГ-27, С/төв 4, ЭМТ-17, | 670 | 5-р сард байгууллагуудын биеийн тамирын хамтлагт орсон хүмүүс байгууллагын ажилтан, албан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хүний эзлэх хувийг нэмэгдүүлнэ. | | СӨБ-22, ЕБС-34, Иргэн 138 нийт – 670 | | хаагчдаас сорил судалгаа, биеийн жингинй индекс авсан. ЕБС-312, СӨБ-98, ЗДТГ-27, С/Төв-4, ЭМТ-17, СӨБ-22, ЕБС-34, иргэд 102 нийт 616 хүүхэд иргэдээс авч мэдээллэсэн байна. Хэрэгжилт 100% |
| | | 17. Төрөлжсөн секц дугуйлангийн тоог нэмэгдүүлэх замаар нийтийн биеийн тамир болон их спортыг хөгжүүлэхэд анхаарч төрийн бодлогоор дэмжин ажиллана. | Хичээллэсэн секц дугуйлангийн тоогоор | -2022 онд 99 хүүхэд Үүнд үндэсний бөх-6, чөлөөт бөх-6, Сагсан бөмбөг эр-13, эм -13 шатар –5, дааманд -6, гар бөмбөг эр 25, эм 25 хүүхэд тус тус хичээллэж байна. | 120 | 2023 онд биеийн тамирын төрөлжсөн секц дугуйланд нийт 99 хүүхэд хамрагдаж байна. Үүнд үндэсний бөх-6, чөлөөт бөх-6, сагсан бөмбөг эр-13, эм-13, гар бөмбөг эр-25, эм-25, шатар-5, дааманд-6 хүүхэд тус тус хичээллэж байна. Хэрэгжилт 100% |
| | | 18. Нийтийн биеийн тамир, спортын стандарт хангасан заал, гадна талбайн засвар тохижилтыг хийж гүйцэтгэнэ. | Талбайг зассан байдлаар | биеийн тамирын гадаа талбайн хашааг сольж будсан | Гадаа талбайн засварыг дуусгана. | Сумын спорт заалны иж бүрэн засвар бүрэн хийгдэж дууссан. Үйл ажиллагаа тогтмолжсон. ЕБС-ийн 300 хүүхэд, СӨБ-ийн 50 хүүхэд 05-р сарын 01 нээс гадаа хичээллэдэг. ОНХС-аас 10,000,000 сая төгрөгний хөрөнгөөр ЕБС-ийн биеийн тамирын талбайн хашааг хийсэн. Мөн дотор замын ажил хийгдэнэ. Хэрэгжилт 70% |
| | | 19. Байгууллага бүрт алхалт, гүйлт, дугуйгаар хичээллэгчдийн клуб, бүлэг байгуулан идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | -Алхалт, гүйлт, дугуйн клуб, бүлгийн тоо<br>-Идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх иргэдийн тоо | 0 | 4 | Сумын хэмжээнд байгууллага бүр алхалт, гүйлтийн 4 баг тус бүр 10 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. Хэрэгжилт 70% |
| | | 20. Аймаг байгуулагдсаны 100-н жилийн ойн хүрээнд төрийн албан хаагчдын спортын наадамд оролцоно. | Спортын төрлийн тоо<br>-Хамрагдсан албан хаагчийн тоо | 0 | Үйл ажиллагаагаар | Хугацаа болоогүй |
| **1.3. Боловсрол** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6. | **Боловсролын үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулна.** | 21. Цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлж, "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. | Хамран сургалтын хувь | 80% тай байна. | 84%-д хүргэнэ. | 2022-2023 оны хичээлийн жилд 6-н бүлгээр 2-5 насны 155 хүүхэд хамруулахаас 143 хүүхэд , нүүдлийн цэцэрлэгт 14 хүүхэд хүлээн авч хамран сургалт 95% байна. Хэрэгжилт-100% |
| | | 22. Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийг төрөл бүрийн дугуйланд хамруулах замаар хүүхдийг хөгжүүлэх ажлыг дэмжин зохион байгуулна | Дугуйланд хамрагдалтын тоогоор | 7 төрлийн дугуйланд 94 хүүхэд хамрагдаж байна. | 7 төрлийн дугуйланд 102 хүүхэд хамруулна. | Сургалт үйл ажиллагааг дэмжих замаар 7 төрлийн дугуйлангийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд: Шатар, даам, могой шоо, гимнастик, спорт өрөлт, найрал дуу зэрэг дугуйланд бэлтэг, ахлах, дунд бүлгийн хүүхдүүдийг хамруулсан. Үүний үр дүнд Т өв аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан "Яргуй-2023"- урлагийн наадамд дуу, бүжгийн төрөлд амжилттай оролцож " Уран жиргээ"- тэмцээнд "Ахлах-А"- бүлгийн Б.Танан хүрэл медаль авч амжилттай оролцсон. Хэрэгжилт-100% |
| | | 23. 5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангаж 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулна. | 6 настай хүүхдийн хамралтын хувь | 2021-2022 онд 81% | 81.5% | 2022-2023 оны хичээлийн жилд тойргийн 5 настай 34 хүүхэд хамруулахаас 28 хүүхдийг СӨБ-ын үйлчилгээ олгосон бол аав ээжийгээ дагаад Улаанбаатар хотод-3 хүүхэд, Дархан уул аймагт-2 хүүхэд СӨБ-ын үйлчилгээнд хамрагдсан. Хэрэгжилт-100% |
| | | | 5 настны хамран сургалтын хувь | СӨБ -100% | 100% | |
| | | 24. Ерөнхий боловсролын сургалтын чанарыг сайжруулж чанарын үнэлгээний үр дүнг ахиулна. | ЭЕШ-ын дундаж оноо, ЧҮШ-ын гүйцэтгэлийн ахиц | 2021 оны дундаж ЭЕШ-518,5 ЧҮШ-22,7 | ЭЕШ-ийн оноог 519,5 ЧҮШ-г 34,0 | 2021-2022 онд 6 судлагдахуунаар ЭЕШ өгч 4 судлагдахуун аймаг болон улсын дунджийг хангаж 2 судлагдахуун улсын дунджид хүрээгүйг анхааралдаа авч гүйцэтгэл багатай даалгавруудаар түвшний даалгавар боловсруулан улсын дунджид хүрэхийг зорин ажиллаж байна. Үүнд: НУ-ны судлагдахуунаар аймагт 3-р байр, физик 4-р байр, англи хэл 4-р байр, газар зүй 4-р байранд орж АОД – 43.6 оноо ХОД - 511.2 оноо авч |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийлбэр дүнгээр аймагтаа 6-р байранд орсон.<br><br>Хэрэгжилт:100% |
| | | 25. Багш, удирдах ажилтны мэдээлэл холбооны технологи ашиглах чадвар, цахим контент бэлтгэх мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн ажлын байран дээрээ хөгжих орчин бүрдүүлэн Багш бүрийг зөөврийн компьютр, таблетаар хангана. | Шаардлага хангасан зөөврийн компьютерийн тоо /багшийн компьютер/ | 3 | 3 | Гүйцэтгэлийн үнэлгээнд 3-р түвшинд үнэлүүлэн ажилласны үр дүнд сургалтад ашиглах зорилгоор таблет 3ш, худалдан авалтаар, Ц. Тувааны ажлын албанаас делл брэндийн зөөврийн компьютер тус бүр 2ш хүлээлгэн өгсөн.<br><br>Хэрэгжилт:100% |
| | | | Ээлжит хичээлийн цахим контентын тоо | 6 контент,илтгэл, ур чадварын хичээлүүдийг байршуулсан. | 3-р нэмэгдүүлнэ | |
| | | 26. “Оюунлаг - Төв аймаг” хөтөлбөр хэрэгжүүлж, багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнг суралцагчдын сурлагын амжилтын ахицаар үнэлж, багшийн хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан үнэлгээг хэрэгжүүлж, “Шилдэг багш, хамт олон” болзлыг хангаж ажиллана. | Анги нийт /масс/-ийн сургалтын гүйцэтгэлийн хувь<br><br>Шалгуур хангасан “Шилдэг багш, хамт олон”-ы тоо | 0 | Бага ангиас -1<br>Дунд ангиас -1<br><br>Ахлах ангиас-1 | Жил бүр уламжлал болон зохиогддог багш нарын “Ур чадвар”-ын уралдаан амжилттай болж багш нар бие биенээсээ туршлага судлан шинэлэг арга зүйг туршин сурагчдыг сурах үйлд идэвхжүүлсэн сонирхолтой хичээлүүд заагдсан ба уг уралдаанд ДУДТ-ийн багш Д.Эрдэнэбилэг 1-р байр, бага ангийн багш Я.Ичинхорол 2-р байр, орос хэлний багш М.Отгончимэг 3-р байр эзэлж багш нараа хошуучиллаа. Бага ангийн сурагчдын уншиж ойлгох болон математикийн суурь чадварыг оношлох, хөгжүүлэх, арга зүйг хэрэгжүүлэх чиглэлээр багшийг ажлын байранд нь тасралтгүй дэмжиж, сургууль, багш нарт зөвлөн туслах зорилгоор орон нутгийн зөвлөн туслах баг байгуулагдсанаар бага ангийн багш нар төлөвлөгөөний дагуу явцын үнэлгээний арга зүйг монгол хэл, математикийн хичээлд хэрхэн хэрэгжүүлж байгаагаа бусадтай хуваалцаж 5 багш бүсэд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хичээл заан хамтран ажиллалаа. 2022оны 11 дүгээр сарын 09 өдрийн 09\43 тоот байгууллагын албан тоотыг Эй плас интернэйшнл ХХК-д илгээн багш нар сургалтад оролцох эрхээ баталгаажуулан өөрийн бүртгэлтэй gmail хаягаараа нэвтэрч багш ажлын байрандаа тасралтгүй хөгжих түүгээр дамжуулан мэдлэг боловсролоо дээшлүүлж мэргэжлийн бүлгээрээ сургалтад хамрагдаж байна.<br>Хэрэгжилт:100% |
| | | 27. ЕБС, СӨБ-ыг Мэргэжлийн багшаар хангах, зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлнэ. | Мэргэжилтэй багшийн тоогоор | ЕБС-17 багш мэргэжилтэй<br>ЕБС- Мэргэжлийн багш -90% зэрэгтэй багш-7 | Зэрэгтэй багшийн тоог 3- өөр ахиулна. | Шинээр 2023 оны 01 дүгээр сард Бага ангийн багш Ш.Баасандулам, Ч.Шүрэнцэцэг, физик математикийн багш О.Сонинцэцэг, нарт заах аргач багш, нийгмийн ухааны багш Г.Болормаад тэргүүлэх зэргийг шинээр олгон зэрэгтэй багш нарын тоог нэмэгдүүлэн багшийг ажлын байрандаа хөгжих тал дээр анхааран ажиллаж байна. Зэрэгтэй багшийн эзлэх хувь 83% |
| | | | | СӨББ-7 багш мэргэжилтэй | 8 | 2022-2023 оны хичээлийн жилд нийт арга зүйч-1, багш-6 ажиллаж байна. Мэргэжлийн багшийн хангалт -89%, |
| | | | | СӨББ- зэрэгтэй багш-4 | 6 | Баклавр зэрэгтэй -7 багшаас 6 эзлэх хувь 86% /1 оюутан багш/<br>Магистр зэрэгтэй-3 эзлэх хувь 33%<br>Заах аргач багш-6<br>Тэргүүлэх-1<br>Хэрэгжилт-100% |
| **7.** | **Хүн бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй** | 28. Суурь болон Бүрэн Дунд Боловсрол эзэмших хүсэлтэй иргэдийг НТБ-ын сургалтаар | Суурь болон Бүрэн Дунд Боловсрол эзэмшсэн | 9 суралцагчаас бага боловсролд- 3<br>Суурь болон Бүрэн | Бүрэн дунд боловсролд 2 төгсөгч төгсгөнө. | Бага боловсрол -2 сурагч, суурь боловсрол -5 сурагч, бүрэн дунд боловсрол -2 сурагч суралцаж |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **эзэмших нөхцөлийг бүрдүүлнэ.** | дэмжин хөгжүүлж боловсрол олгоно. | суралцагчдын тоогоор | дунд боловсролд- 6 | | байна. Үнээс ганцаарчилсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд 5 сурагч Э.Мягмардулам, Ц.Хүчитбаатар, Б.Ариунжаргал О.Шинэбаяр, Л.Бадамгарав нарын гэрээр 14 хоногт 1 удаа явж, тухайн хүүхдийн хөгжлийн онцлогт тохирсон даалгаврыг бэлтгэж хичээл зааж ажиллаж байна. Хэрэгжилт:70% |
| | | 29. Сургууль, дотуур байрны засвар шинэчлэлийг хийж, суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ. | Дотуур байрны таазыг уналттай тааз хийх | Дотуур байрны халаалтыг сайжруулж 2021-2022 оны хичээлийн жилд секц тоог тасаг тус бүрд 6 нэмсэн. | Халаалт дулааныг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах | Сумын засаг дарга, сургуулийн захирал нарын хооронд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсанаар дотуур байрны халаалт дулаан паар секцийн тоог нэмэгдүүлэн ажиллахаар 90см урттай 6 ширхэг паарыг худалдан авч дотуур байрны 6 тасагт тус бүр нь 6 ширхэг секц нэмж холболтийг хийж халаалтыг сайжруулан ажилласан. 2022-2023 оны хичээлийн жилд 6 настай О.Отгонбаяр хамрагдсан. Хүний эрхийн үндэсний хорооны Төв аймаг дахь референт У. Чойжилсүрэн 2023.05.22 өдөр дотуур байрны орчин нөхцөлтэй танилцаж нүдээр үзэн хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид анхаарах асуудал дээр заавар зөвлөгөө өгөн ажилласан. Хэрэгжилт: 100% |
| | | | Хүүхдэд ээлтэй дотуур байр хөтөлбөрийн хүрээнд жишиг тасгийн тоог 2-р нэмэгдүүлэх. | 2019-2020он 2020-2021 оны хичээлийн тус бүрд жишиг тасаг 2 тохижуулсан. | Жишиг тасгийн тоог 2-р нэмэгдүүлж жишиг тасаг 4 болно | |
| | | 30. Цэцэрлэгийн “А” байрны барилгын их засвар хийх | Их засвар хийлгэсэн байдлаар | Зураг төсөв хийгдсэн | Их засварыг бүрэн хийж дуусгах | Цэцэрлэгийн “А” байрны их засварын төсөв хийгдсэн Хэрэгжилт: 30%. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 31. Цэцэрлэгийн бүх бүлгүүдийн тоглох тоглоомыг шинэчлэх ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ | Тоглоомын тоог нэмэгдүүлэх | Хүүхдийн тоглох тоглоом дутагдалтай | 6 бүлгийн тоглоом сольсон байх | Сургалтын орчин сайжруулах зорилгоор 1,500,000 мянга, нэг бүлэгт 250-н мянган төгрөгний толоом авсан.<br>Хэрэгжилт-70% |
| | | 32. СӨББ-ын сургалтын материал хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг ээлж дараатай зохион байгуулна | Тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлнэ | 2 принтер, 1 нөүтбүүк суурин компьютертэй болсон. | 1 проктер, дэлгэц | БҮТ-өөс багшийн ажлыг гүйцэтгэлийн үнэлгээгээ IV-р түвшинд үнэлэгдэн орчин сайжруулах чиглэлээр 1,200,000 мянган төгрөгөөр ЗАН-д сургалтын хэрэглэгдэхүүн тоглоом наадгай авсан.<br>“Туваан сан”-гаас 2,700,00 төгрөгний 1 нөүтбүүк өгсөн.<br>Хэрэгжилт-70% |
| | | 33. Бичиг үсэг үл мэдэгч иргэдийг илрүүлэн НТБ-д хамруулж зохих шатны боловсрол олгоно | Бичиг үсэг үл мэдэгч иргэдийг илрүүлэн НТБ-д хамруулж тоог бууруулна. | Бичиг үсэггүй 13 иргэн | Бичиг үсгийн анхан шатны мэдлэг чадвартай болгоно. | 3 иргэнд Ганцаарчилсан сургалтын сурагчдын өөр өөрсдийн чадамжид тааруулан дүрс таниулах, өнгө таниулах, тоо таниулах, унших сургах, бичиж сургах, ушсан зүйлийн ойлгосныг яриулах, зураг зурах, цаасан урлал хийх,бусдад өөрийгөө илэрхийлж сурах, дуу дуулах, шүлэг унших, цээжлэх чадваруудыг эзэмшүүлж байна.<br>Хэрэгжилт:70% |
| | | 34. Сурагчдын хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааг дэмжих замаар хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлнэ. | Сургалтад хамрагдсан байдлаар | Амжилт гаргасан хүүхдийн тоо | Уралдаан тэмцээнд байр эзлэлтийн хувиар | 2022-2023 оны хичээлийн жилийн намрын стапартакад, урлагийн бага наадам зэргийг амжилттай зохион явуулж хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан сурагчдыг хөгжүүлж олон талт үйл ажиллагаануудыг зохион явуулж байна. Үүнээс дурьдвал: Намрын стапартакдад бага ангийн төрөлд Л.Баярмаа багштай 5а анги, дунд ангийн төрөлд О.Сонинцэцэг багштай 9а анги, ахлах ангийн төрөлд Г.Болормаа багштай 12а ангиуд тус бүр байруудыг эзэллээ. Урлагийн бага наадмыг 5 төрлөөр |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022.12.07 өдөр сумын соёлын төвийн урлаг зааланд зохион байгууллаа. Бага ангиудаас Л.Баярмаа багштай 5а анги, дунд ангиас Б.Мөнхзул багштай 7а анги, ахлах ангиас Б. Өлзиймаа багштай 10а ангиуд тэргүүн байруудыг эзэлсэн бол энэ жил онцлог хэлбэрээр дунд ангийн сурагчид бөх, морины цол дуудах зэргээр зохион байгуулсан нь давуу талтай үйл ажиллагаа боллоо. Бүтээлч багачууд уралдаанд 1-2 ангийн төрөлд 2а ангийн “ Дөрвөн бэрх” баг аймагт 3-р байр,3-4р ангийн төрөлд 3а ангийн “Динзо” баг 3 байр эзэлсэн.<br>Хэрэгжилт: 100% |
| | | 35. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчин нөхцөлийг сайжруулж, тэдэнд ээлтэй сургалтын орчныг бүрдүүлнэ. | НТБ-оор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг суралцуулсан байна. | НТБоловсролоор хөгжлийн бэрхшээлтэй 3 хүүхэд суралцаж байгаа. | ХБ-тэй хүүхдэд суурь боловсрол эзэмшүүлнэ. | Боловсрол нөхөн олгох хөтөлбөрийн ганцаарчилсан сургалтаар нийт 5 сурагч хичээллэж байна. Үүнээс эмэгтэй 3, эрэгтэй 2. 1-р ангид 2, 7-р ангийн 2, 9-р ангид 1 сурагч суралцдаг. Эдгээр сурагчид нь даун, сэтгэцтэй хавсарсан бэрхшээлтэй , хөдөлгөөний бэрхшээлтэй, хэл ярианы бэрхшээлтэй. Э.Мягмардулам Ц.Хүчитбаатар Б.Ариунжаргал Л.Бадамгарав О.Шинэбаяр нарын гэрээр 14 хоногт 1 удаа явж монгол хэл, уран зохиол, нийгэм, эрүүл мэнд, бие тамир, дүрслэх урлаг, зургийн хичээл заах ажиллаж байна.<br>Хэрэгжилт: 70% |
| | | 36. “Хөгжсөн багшаас чадварлаг сурагч” хөтөлбөрийг үргэлжлүүлж, багшийн хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан үнэлэмжийг бий болгоно. | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 91% | 93% | Багш нар мэдлэг боловсролоо дээшлүүлж БМДИ-ээс зохион байгуулдаг 1,5,10 дахь жилийн үндсэн сургалтад 2022-2023 онд 10 дахь жилийн сургалтад Захирал |
| | | | Мэргэжлийн багшийн хангалтын хувь | 94.0 | 95.0 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Р.Гэрэлсайхан,нийгмийн ухааны багш Г.Болормаа, Мэдээлэлзүй математикийн багш Э.Цэрэннадмид 5 дахь жилийн сургалтад математикийн багш М.Бүжин Одоогийн байдлаар Global удирдагч их сургуулийн магистрийн ангид 4 багш, УБ Эрдэм ИС-ийн магистрийн ангид 2 багш, ИдэрИС-ийн магистрийн ангид 1 багш нийт 7 багш магистрантурт сурч байна. Багш нар цахим сургалтын олон талт хувилбаруудаас суралцан орчин үеийн "Forms", "Google meet", "Zoom", "Google form", "Google classroom" программуудыг сургалтдаа ашиглаж хичээл сургалтыг тасралтгүй явуулж ирлээ. Хэрэгжилт:100% |
| | | 37. ЕБС-ийн сурагчдын ширээ сандал шинэчлэх ажлыг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ. | 2023 онд 30 ширээ 70 сандал, 6 настай сурагчдад 20 ширээ 40 сандалтай болно | Сурагчдын ширээ сандал дутагдалтай. | 6 настай сурагчдын болон дунд ахлах ангийн 1 ангид ширээ сандлыг шинэчилсэн байна. | УИХ гишүүн Ц.Туваааны ажлын албанаас ангиудын сурагчдын ширээ сандлыг 9,544,000 төгрөгний шинэ ширээ сандалтай болсон. Хэрэгжилт:100% |
| | | 38. ЕБС-ийн мэдээлэл зүйн танхимыг тохижуулж, тоног төхөөрөмжтэй болгоно. | Мэдээлэлзүйн кабинет тохижуулсанаар | - | Мэдээлэлзүйн кабинеттэй болсон байна. | Хугацаа болоогүй худалдан авалт тендер шалгаруулалт зарлагдаагүй. Хэрэгжилт:30% |
| **1.4. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал** | | | | | | |
| **8.** | **Гэр бүл, хүн амын бүлгүүдэд ээлтэй хөгжил, оролцоо, хамгааллын орчныг бүрдүүлж,** | 39. "Гэрлэх ёслол"-ын танхимыг тохижуулах, залуу гэр бүлийг гэрлэлтэд бэлтгэх болон гэр бүлийн бат бэх харилцааг дэмжих | Гэр бүлийн хосын тоо | 0 | 2 | 2023 онд 1 өрх шинээр гэр бүлээ батлуулсан. Мөн ОУ-ын гэр бүлийн өдрийг удирдамжийн дагуу зохион байгуулахад 102 хүүхэд 89 иргэн хамрагдсан байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **үр ашигтай орон нутгийн тогтолцоог бэхжүүлнэ.** | үйл ажиллагааг тогтмолжуулна | | | | Хэрэгжилт 100% |
| | | | Гэрлэх ёслолын танхим байгуулсанаар | 0 | Танхимыг засварлан шинэчилнэ | Гэрлэх ёслолын танхимын засварын ажлыг хийж дуусган үйл ажиллагаа явуулж байна. Хэрэгжилт 100% |
| | | 40. Хүүхдийн эрхийг хангахад, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулж, оролцоог нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмолжуулан, сумын хамтарсан баг,сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг бэхжүүлнэ | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Хамгааллын чиглэлээр 4 арга хэмжээ | 5 арга хэмжээ | Хүүхдийн төлөө зөвлөлөөс Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхэд гэж хэн бэ? Сургалтуудыг 2023 оны 02 сарын 27 нд БНА-тай хамтран зохион байгуулсан. Нийт 52 эцэг эх хамрагдсан. Мөн хамтарсан багаас Хүүхэд хамгааллын бодлогын сургалтыг хийж төсвийн 5 багууллагын ажилтан албан хаагчид ХХБ-д гарын үсэг зурж баталгаажуулан ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй 3 өрх, архины хамааралтай 3 өрхөд гэр бүлийн боловсрол олгох зөвлөгөө, холбогдох хуулийн заалтуудаар мэдээллийг 12 хүнд өгсөн. Мөн архины хамааралтай, хүн цуглуулж архи уудаг 5 өрхөд хэсгийн төлөөлөгч хяналт тавин ажиллаж байна. СӨБ: Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс хамгаалах зорилгоор ахлах бэлтгэл бүлгийн хүүхдүүдэд газар хөдлөхөд өөрийгөө хэрхэн хамгаалах “Суу, нуугд, хүлээ,” “Галын аюулаас хэрхэн сэргийлэх” талаар хүүхдийн нас сэтгэхүйд тохирсон сургалтыг багш Гандолгор, Б.Батчимэг нар явуулсан. ЕБС: 2023 оны 03-р сарын 04 нд Дэлхийн ЗӨН-тэй хамтран хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэе сургалтыг хийхэд 38 |
| | | | Дуудлага мэдээллийн тоо, Кейс шийдвэрлэлтийн тоогоор | Кейс шийдвэрлэлт 100%, Дуудлага мэдээллийн тоо 3 | Кейс шийдвэрлэлт 100%, дуудлага мэдээллийн тоог өсгөхгүй | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эцэг эх хамрагдсан. Мөн гэр бүлд хүүхэд хамгааллын зөвлөгөө мэдээллийг цахимаар 8 удаа тавихад 187 хүн тандалт хийсэн байна. 2023 оны 05 сард аймгийн ГБХЗХГ-аас зохион байгуулсан “Гэр бүлдээ үүнийг хүсдэг” гар зургийн уралдаанд 3 хүүхдийн бүтээлийг цахим болон цаасан хэлбэрээр явуулан 3-р байранд Б.Цовоо орсон.<br><br>Хэрэгжилт 100% |
| | | 41. Гэр бүлийн хөгжил, оролцоог дэмжихэд чиглэсэн ”Залуус” бичил төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Залуу малчин 1 гэр бүл уулзалтанд оролцсон | 2 гэр бүл | 1-р багийн иргэн Л.Тулга нь ХЭДС-ийн ажлын байр дэмжих төсөлд “Авто засвар үйлчилгээ” 10,000,000 сая төгрөгийн төсөлд, Я.Отгондоржхүү ХБИАБХТөсөл хөтөлбөрт блокны үйлдвэрлэлээ 5000,0 төгрөгөөр хамрагдсан.<br>Хэрэгжилт 100% |
| | | 42. Байгууллага бүр хүүхдийн өрөөтэй болно. | Хүүхдийн өрөөтэй болсон байгууллагын тоо | ЕБС, СӨБ | 4 | Төсвийн 5 байгууллага хүүхдийн өрөөтэй болсон .<br>Хэрэгжилт 100% |
| **9.** | **Зорилтот бүлгийн өрхүүдэд чиглэсэн амьжиргааг дэмжих төсөл хэрэгжүүлнэ.** | 43. Төгсөлтийн аргачлал” төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2-р үе шатыг хэрэгжүүлнэ. | Амьжиргаа дээшилсэн өрхийн тоо | 14 | 22 | Төгсөлтийн аргачлал төсөл хөтөлбөрийн 2-р үе шатыг хэрэгжүүлэн ажиллаж нийт 22 өрхийн амьжиргааг дээшлүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар 17 өрхийн амьжиргааны түвшин ахисан үзүүлэлттэй байна.<br>Хэрэгжилт 100% |
| | | 44. Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ойд зориулж 100 өрхийг “Гэр” төсөлд иргэдийг хамруулна. | Гэр төсөлд хамрагдсан өрхийн тоо | 1 | 2 | Гэр төсөлд 1 өрхийг хамруулсан 1 өрхийг хамруулахаар материалыг нь бүрдүүлэн явуулсан.<br>Хэрэгжилт 90% |
| **10.** | **Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн** | 45. Малчин хувиараа хөдөлмөр эрхлэгч, оюутнуудыг эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулна. | ЭМДаатгал хамрагдсан хүний тоо | 2022 оны байдлаар 164 иргэн хамрагдсан | 180 иргэн | Нийт ЭМДаатгалын дутуу төлөлттэй 500-гаад иргэдийн судалгааг гарган одоогоор 78 иргэнээр 2019-2023 он дуустал төлүүлээд байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **хамгаалал, даатгалд хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | Сайн дурын даатгалд хамрагдсан хүний тоо | Сайн дурын даатгалд хамрагдсан хүний тоо 122 | 130 иргэн | Зудаагийн нийтийг хамарсан сургалт сурталчилгаа хийснээр 106 иргэн хамрагдсан. Хэрэгжилт-100% |
| | | 46. Цахим нийгмийн даатгалын үйлчилгээг өргөжүүлэн, "Нийгмийн даатгал" гар утасны аппликейшн хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлнэ. | Гар утасны аппликейшн хэрэглэгчдийн тоо | 2022 оны байдлаар 75 иргэн хамрагдсан | 90 иргэн | Он гарснаас хойш 47 иргэнд аппликейшн нээж үйлчилгээ үзүүллээ. Хэрэгжилт-50% |
| | | 47. Бүтээн байгуулалтын ажлууд, тусгай сангуудын санхүүжилтээр шинэ ажлын байр бий болгоно**.** | Шинээр бий болсон ажлын байрны тоо | 40 | 40 | Шинээр 20 иргэн ажлын байраар хангагдан ажилласан. |
| | | | Ногоон ажлын байрны тоо | 10 | 10 | Хугацаа болоогүй |
| | | | Нийтийг хамарсан ажлын байрны тоо | - | 10 | Хугацаа болоогүй<br><br>Хэрэгжилт 30% |
| | | 48. Улирлын чанартай түр ажлын байрыг бий болгоно. | Түр ажлын байрны тоо | 491 | 500 | Түр ажлын байраар 300 иргэн хангагдан ажилласан. Хэрэгжилт100% |
| | | 49. "Халамжаас хөдөлмөрт" зорилтын хүрээнд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлж Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээгүй өрхийн тоог нэмэгдүүлнэ. | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авагч өрхийн бууралтын хувь | 31% | -5% | Хүнсний эхрийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 13 өрхийн амьжиргаа дээшлэн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс хасагдсан.<br><br>Хэрэгжилт 100% |
| | | 50. Иргэдийн мэргэшлийн ур чадварыг хөгжүүлж, хөдөлмөрт бэлтгэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | Мэргэжлийн ур чадвар эзэмших сургалтад хамрагдсан иргэдийн тоо | | 1 | Хугацаа болоогүй |
| | | | -АМЧБОЗӨҮ-нд хамрагдсан иргэдийн тоо | 10 | 10 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд төгсөх ангийн сурагчид болон ажилгүй 3 иргэн хамрагдсан. |
| | | | -Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо | 1 | 1 | Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ болон ААЭ-х сургалтанд 4 иргэн хамрагдсан. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хэрэгжилт 70% |
| | | 51. Сул чөлөөтэй ажлын байрны захиалгын дагуу ажилгүй иргэдийг хөдөлмөрт бэлтгэж, ажлын байранд зуучилна. | Зуучлагдсан иргэдийн тоо | 2021 онд 12 иргэнийг ажилд зуучилсэн. | 15 иргэнийг сул чөлөөтэй ажлын байранд зуучилна. | Сул чөлөөтэй ажлын байранд 14 иргэнийг зуучилсан. Хэрэгжилт 100% |
| **1.5. Үндэсний бахархал, өв соёл** | | | | | | |
| **11.** | **Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.** | 52. "Төв түмний цэнгэл" баяр наадамд удирдамжийн дагуу оролцоно. | Наадамд оролцсон тоогоор | Төв түмний цэнгэл наадамд сумаас 35 хүн оролцож 4 төрлийн тэмцээн уралдаанд амжилттай оролцсон | Төрийн ба ТББ, иргэдийг оролцуулна | Хугацаа болоогүй |
| | | 53. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн онцлогт тулгуурласан аймгийн дунд хугацааны стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. | Төлөвлөгөөний хэрэгжилтээр | Соёлын бүтээлч сарын аяны хүрээнд 13 арга хэмжээ зохион байгуулж 2574 иргэнд үйлчилсэн | Хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана | Соёлын сэргэлт – 2023 он аяны хүрээнд 5 арга хэмжээ зохион байгуулж нийт -6000 иргэнд үйлчилсэн. Хэрэгжилт 100% |
| | | 54. Нийтийн номын сангийн тавилга, мэдээ мэдээллийг цахимаар хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. | Тоног төхөөрөмжийн тоогоор | Проекторотой, дэлгэцтэй болсон | Зөөврийн комьютертай болно | ДЗОУБ-д хүсэлт гарган 1.256.164 төгрөгийн проектор, дэлгэцтэй болсон . Хэрэгжилт 100% |
| | | 55. Номын сангийн байнгын уншигч иргэдийн тоог нэмэгдүүлнэ. | Байнгын уншигчийн тоогоор | 11% | 13% | Номын сангийн байнгын уншигчийн тоо- 142 уншигч, ирэгсэд -623, нийт -765 уншигчдад 1191 ширхэг ном сэтгүүл олгож үйлчиллээ. Хэрэгжилт – 90% |
| | | 56. Орчин үеийн урлагийн шинэлэг төрөл хэлбэрүүдийг ардын уламжлалт урлагтай хослуулан | Тоглолтын тоогоор | 5 урлагийн тоглолт зохион байгуулж 3732 иргэнд үйлчилсэн. | 6 | Эхний хагас жилийн байдлаар 4 тоглотыг зохион байгуулж 850 гаруй иргэнд үйлчилсэн байна. |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тоглолт зохион байгуулна. | | | | Хэрэгжилт 90% |
| | | 57. Аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ой угтсан ажлын хүрээнд “Авьяас бидний бахархал” сэдэвт 1000 ардын авьяастан, мэргэжлийн уран бүтээлчдийн урлагийн тоглолтын бэлтгэл хангахад оролцоно. | 100 жилийн ойд оролцсон өвлөн уламжлачийн тоогоор | “Авьяас бидний бахархал” урлагийн наадмыг сумын хэмжээнд зохион байгуулж 105 иргэн хамрагдсан. | “Авьяас бидний бахархал” урлагийн наадмын 2,3-р шатны шалгаруулалтанд оролцоно | Төв аймаг байнгуулагдасны 100 жилийн ойг угтсан “Авьяас бидний бахархал” урлагийн наадамд 4 номертой оролцож Хамтлаг бүжгийн төрлөөр 1-р байр, Хамтлаг дууны төрлөөр 2-р байр тус тус эзэллээ.<br>Хэрэгжилт 90% |
| **12.** | **Түүх соёлын дурсгал, урлагийн бүтээл, утга зохиолд тулгуурлан үндэсний бахархлыг төлөвшүүлж, биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах, өвлүүлэх арга хэмжээг зохион байгуулна.** | 58. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлж нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж дугуйлан хичээллүүлнэ. | Хичээллэсэн хүний тоогоор | Бүжиг-28 | Бүжиг-30 | Соёлын төвийн дэргэд бүжгийн дугуйланд 38 сурагч хамрагдаж 6 бүжиг гаргаад байна.<br>Хэрэгжилт 50% |
| | | 59. Соёл төвийн материалаг бааз, тоног төхөөрөмж, хангалтыг нэмэгдүүлнэ. | Материаллаг баазын тоогоор | Тоног төхөөрөж материаллаг баазын хангалтаар тайзны гэрэтүүлэг, Караоке төхөөрөмж, урлагийн дээл, Проектор<br>Нийт 3536000 төгрөг | материалаг бааз, тоног төхөөрөмж шинэчлэгдсэн тоогоор | 2,056,000 төгрөгний 22 ширхэг Гар бөмбөг, Сетка 1, Оноонь самбар 1<br>Үе үеийн төгсөгчдийн Гар бөмбөг Сагсан бөмбөгийн тэмцээний үеэр 1990 оны анхны 10-р ангийн хамт олон 5 ширхэг гар бөмбөг, 5 ширхэг сансан бөмбөг тус тус хүлээлгэн өгсөн.<br>Хэрэгжилт -100% |
| | | 60. Соёл, урлагийн салбарын ажиллах хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдгээрийг мэргэшүүлэх сургалтад үе шаттай хамруулна. | Мэргэшүүлэх, давтан сургалтад 3 албан хаагчийг 3 удаа хамруулна. | Соёлын төвийн мэргэжлийн боловсон хүчний хангалт 50% | 75% | Товлосон цаг хугацааны Онлайн болон танхимын мэргэшүүлэх сургалтанд 2023оны хагас жилийн байдлаар 2 албан хаагч хамрагдлаа.<br>Хэрэгжилт- 90% |
| **13.** | **Соёл, урлагийн байгууллагын материаллаг бааз, тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлнэ.** | 61. Сумдын соёлын төвийн дарга, номын санч, бүжгийн багш, хөгжмийн багш нарын мэргэжлийн ур чадварын уралдаанд оролцоно. | Хамрагдсан албан хаагчдын тоогоор | 2022 онд 3 албан хаагч 5 удаа сургалтанд хамрагдсан. | 3 албан хаагчийг хамруулна | Ур чадварын уралдаан зарлагдаагүй байна.<br><br>Хугацаа болоогүй |
| **14.** | **Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил,** | 62. ”Хүүхдийн хүмүүжил төлөвшлийг сайжруулах” аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | Сургуулийн орчинд гэмт хэрэг, зөрчлийн тоо нэмэгдээгүй. | 100% хэрэгжүүлнэ. | Спорт өдөрлөг буюу намрын стапартакд, ахмадын баяраар хөдөлмөрийн баатар Цагааншүхэрт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.** | хэрэгжүүлнэ. | | Хүүхдэд чиглэсэн үйл ажиллагаануудыг зохион байгуулснаар төлөвшилд ахиц гарсан. 97.7% | | гуайн хөшөөнд цэцэг өргөх ёслол, дэлхийн охидын өдөр, сургуулийн 6-12р ангийн сурагчдын дунд Бидний оролцоо,бидний эрх, үүрэг хүүхдийн нэгдсэн чуулган, монгол өв уламжлалаар хүүхдээ сурган хүмүүжүүлэхүй сургалтыг 1-5р ангийн 30 эцэг эхчүүдэд, бага ангийн багш, эцэг эх,сурагчдын дунд оноо хурд хором тэмцээн, ангиудын эцэг эхчүүдийн дундах гарбөмбөгийн бооцоотой тэмцээн,сургуулийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн, шинэ жилийн шилдэг чимэглэлтэй уралдаан зэргийг ангийн сурагчдын дунд зохион байгуулан нийт давхардсан тоогоор 227эцэг эх, 1153 сурагчдыг хамруулсан. Хүүхдийн тусламжийн 108утсанд 1 дуудлага очсонг сумын хамтарсан багаар шийдвэрлэсэн ба сургуулийн орчинд гарсан хэрэг зөрчил, сурагчид гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй зүйлд уруу татагдаагүй болно. Сурагчдыг цахимаар болон танхимын уралдаан тэмцээнд бэлтгэж оролцуулан авьяас чадваруудыг нь хөгжүүлж ,бусдад үлгэр дууриайлал болох олон талт ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>Хэрэгжилт:100% |
| **15.** | **Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.** | 63. “***Өв соёлоо эрхэмлэж, үндэсний бичгээ сурцгаая - 2025***” аян өрнүүлэн, төрийн албан хаагчдын монгол хэл, бичгийн мэдлэг, чадварыг дээшлүүлнэ. | Монгол бичгийн сургалтад хамрагдсан төрийн албан хаагчийн эзлэх хувь | МХБУЗ-ын багш НТБ-ын багш нар хамтран 5 байгууллагад анхан шатны сургалтыг зохион байгуулж ажилласан. | Сумын хэлний бодлогын салбар зөвлөл үе шаттай зохион байгуулж хамрагдалтыг 40% хүргэнэ. | “Үндэсний бичиг -3 “хүрээнд ТАХ-ийг монгол бичигт сургах ажлын хүрээнд ТАХ-аас барианы шалгалтыг авч 70-аас дээш хувийн гүйцэтгэлтэй 16 төрийн албан хаагчдад анхан шатны сургалтыг амжилттай дүүргэсний гэрчилгээг гардуулан өглөө.<br>Хэрэгжилт:90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, өндөр бүтээмжтэй, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн үйлчилгээг дэмжих замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж ажиллана.** | | | | | | |
| **2.1. Эдийн засаг, төсөв санхүү** | | | | | | |
| **16.** | **Өрхийн үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлж, ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 4-8%-иар өсгөн, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.** | 64. Эдийн засгийн бүтэц дэх боловсруулах үйлдвэр, үйлчилгээний салбарыг дэвшилтэт технологи, инновацид суурилан хөгжүүлж, ДНБ-ий жилийн дундаж өсөлтийг 6 хувиар хангана. | Сумын ДНБ-ний өсөлтөөр /Өмнөх оноос/ | Тайлант онд ДНБ-ний жилийн дундаж өсөлт 6%-д хүрсэн | Сумын ДНБ 8%- д хүрсэн байна. | 2023 оны эхний 5 сарын байдлаар ДНБ өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1,4 хувиар өссөн дүнтэй байна. ДНБ тооцох 16 нэр төрлийн бүтээгдэхүүнээс 8 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл явагдаж байна. 8 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн дүн 3-р улирлын эцсээр гарах тул одоогоор жилийн дундаж өсөлт 70 хувьтай байна. Хэрэгжилт:70% |
| **17.** | **Төсвийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулна.** | 65. Орон нутгийн төсвийн орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлнэ. | Төсвийн орлого /сая, төг/ | 2022 онд 3-н шатны төсвийн орлого 85.9 %-тай байна. | Төсвийн орлого өмнөх оноос өссөн байна. | Нийт орлогын төлөвлөгөө / 1-5 сар өссөн дүнгээр/ 70,907.5 мянган төгрөг, гүйцэтгэл нь 88,794.2 мянган төгрөг биелэлт нь 125.2%-тай. Нийт 12 нэр төрлөөс 9 нэр төрлийн орлого 100%-803.2%-иар биелэж, 3 нэр төрлийн орлого 75.8%-93.3%-иар тасарсан байна. Хэрэгжилт:100% |
| | | 66. Урьд оны татварын өр барагдуулалтыг стандарт хэмжээнд бууруулж ажиллана. | Татварын өр барагдуулалтын хувь | Өрийн барагдуулалт 26.1 хувиар буурсан байна. | Өр барагдалтын хувийг 30 хувьд хүргэнэ. | Урьд оны өр 125,210.8 мянган төгрөг барагдуулалт 37,556.0 мянган төгрөг, нийт өрийн 30 хувийг барагдуулсан байна. Хэрэгжилт 100% |
| | | 67. Төсөв санхүүгийн нэгдсэн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай үр ашигтай болгож, төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулна. | Нэгдсэн цахим систем нэвтрүүлж,төсвийн хэмнэлт, хувь | 2021-2022 онд шилжих үлдэгдэл 42 сая | - | 2023 оны хагас жилийн байдлаар Золбин нохой муур устгалтын ажлыг 2 сая төгрөгөөр гүйцэтгэсэн. НХГэрээний хүрээнд Аймгийн 100 жилийн ойгоор Цомцог гэр 19.8 саяаар гэрээ байгуулж урьдчилгаа төлбөр болох 10 сая төгрөг шилжүүлж тухайн ажлыг эхлүүлсэн. ОНХСангийн малын тоо толгойн албан татвараар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Огтоно устгалын ажлыг хийж гүйцэтгээд байна. хэрэгжилт 70% |
| | | 68. Төсвийн ил тод байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ. | Шилэн дансанд мэдээлэл байршуулсан хувь | 90% | 92,4% д хүргэнэ. | 2023 оны 06 сарын байдлаар шилэн дансны мэдээллээ бүрэн шивж оруулсан . Хэрэгжилт 70% |
| | | 69. Төсвийн болон орон нутгийн төсөвт байгууллагын худалдан авалтыг www.tender.gov.mn цахим тендер шалгаруулалтын үйл ажиллагаагаар дамжуулж сүүлийн үеийн дэвшилтэт технологид тулгуурлан зохион байгуулж ажиллана. | Нийт зарласан тендерт цахим тендерийн эзлэх хувь | Тендерийг 100% цахимаар зохион байгуулсан. | Тендерийг 100% цахимаар зохион байгуулна. | 2023 оны эхний хагас жилийн байдлаар Хүүхдийн тоглоомын талбайн тохижолтонд 3 аж ахуй нэгж оролцож Арцат алтай констракшн шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. Ахуй үйлчилгээний засвар ажил Тэян Энержи ХХК шалгаран ажлаа эхлээд явж байна. Хэрэгжилт 70% |
| | | 70. Төсөвт байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, үр ашигтай ажиллуулахад мэргэжлийн удирдлага зохицуулалтаар хангаж, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | Өмч ашиглалтанд хяналт тавьж ажиллана | УИХ-ын баталсаны дагуу үзлэг тооллогоор үндсэн хөрөнгийн чанар байдал, хадгалалт, хамгаалалт төрийн өмчийн улсын нэгдсэн бүртгэл хөтөлж цахим мэдээллийн сан буюу хур систем ашигладаг болж байгаа. Төрийн болон орон нутгийн өмчийн үзлэг тооллогод манай сум 100 хувь | Өмч хөрөнгийн хяналтын тооллогыг хагас бүтэн жилээр зохион байгуулж хяналт тавина | 2023 оны өмч хамгааллын зөвлөл хагас жилийн захирамж гарган байгууллага тус бүр дээр ажиллаж байна. Хөрөнгө тооллого эхлүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт 70% |
| | | 71. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан эх оронч, дотоодын үйлдвэрлэлийн худалдан авалтыг дэмжинэ. | Дотоодын худалдан авалтын дүн, сая.төг | 60.0 | Өссөн дүнгээр | 2023 оны худалдан авах ажиллагааны журмын дагуу Үдийн цай болон Хоол хүнсний тендер зарлан ажиллаж байна. Дотоод худалдан авалтыг дэмжих үүднээс тендерийн баримт бичгийг 2 багцтай зарлан ажиллаж байна. Хэрэгжилт 70% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **ГУРАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хослуулан эрхлэх “Хөдөө аж ахуйн стратегийн бүс нутаг” “Өрхийн болон цехийн хэмжээнд явуулдаг Хүнс үйлдвэрлэгч болж салбарын хөгжлийг дэмжиж ажиллана.** | | | | | | |
| **3.1. Газар тариалангийн үйлдвэрлэл** | | | | | | |
| **18.** | **Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэн тариалангийн талбайн ашиглалтыг 80-аас доошгүй хувьд хүргэж, салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамлын тариалалт, ургацаар аймагт тэргүүлэх зорилтыг хангана.** | 72. “АТАР IV” аян, тариалангийн бүс нутаг тогтоосон шийдвэрийг хэрэгжүүлж, тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэх бодлогыг дэмжин, тариалангийн салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. | Бодлого, төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Бодлого, төлөвлөгөөний хэрэгжилт үр тариа 39,1%, төмс 85,2%, хүнсний ногоо 119,3%,тэжээлийн ургамал 67% тус тус хэрэгжсэн байна. | 70% | 2023 оны тариалалтын явцын байдлаар үр тариа 99,2%, тэжээлийн таримал 10%, тосны ургамал 10%, төмс 133%, хүнсний ногоо 8,5%-тай тариалсан байна. |
| | | | Тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо | 37 | Өссөн дүнгээр | 38 өрх эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байна.<br><br>Хэрэгжилт 70% |
| | | 73. Сумын газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжлийн хэтийн зорилгыг тодорхойлон дунд хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөгөө боловсруулж тайлагнана. | дунд хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөгөө боловсруулж тайлагнагдсан байдлаар | - | Дунд хугацааны төлөвлөгөө гаргасан байна | 2023-2025 оны сумын газар тариалангийн бодлогын 2023 оны өлөвлөгөөг сумын ээлжит есдүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.<br><br>Хэрэгжилт 100% |
| | | 74. Тариалангийн талбайн тооллогыг мэргэжлийн байгууллагын оролцоотой хийж, нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулан, голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг хангана. | Эргэлтийн талбай, / га, хувь/ | 4490,59 га | Тариалангийн талбайн эргэлтийг 70-%-иас доошгүй | Тариалангийн талбайн тооллогыг 7 сард ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамт хийхээр ажлын төлөвлөгөөндөө тусгасан байгаа.<br>Одоогийн байдлаар 2983 га-д тариалалт хийгдсэн. Тариалалт дуусаагүй байгаа. |
| | | | Үр тарианы үйлдвэрлэл<br>/ га /<br>/тн/ | 2022 он<br>Тариалсан 1995 га<br>Хураасан: 2877.5тн<br>Нэгжийн ургац 12,5цн | 3000 га<br>4050 тн | 2480 га-д үр тариа тариалсан. Тариалалт дуусаагүй байна. |
| | | | Төмсний үйлдвэрлэл<br>/ га /<br>/тн/ | 2022 он<br>Тариалсан: 256 га<br>Хураасан: 2486 тн | 270га-гаас 3500тн | 346 га-д төмс тариалсан. Төлөвлөгөөт дүнгээс 133%-тай хэрэгжиж байна. Тариалалт |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | нэгжийн ургац 130цн | | дуусаагүй байна. |
| | | | Хүнсний ногооны үйлдвэрлэл / га / /тн / | 2022 он Тариалсан: 83.51га Ургац: 906.2 тн | 70 га-д тариалж 935 тн ургац авах зорилттой. | 7,2 га-д хүнсний ногоо тариалсан. Тариалалт нэмэгдэнэ. Хэрэгжилт 70% |
| | | 75. Тариалангийн талбайг хашаажуулан тэг элдэншүүлгийг нэвтрүүлэн ээлжлэн тариалалтыг нэмэгдүүлэх, Тариалангийн талбайн агрохимийн шинжилгээг эзэмшигч бүрээр хийлгүүлэх, шим болон эрдэс бордоог зохистой хэрэглэх замаар хөрсний элэгдэлийг бууруулж, үржил шимийг хамгаална. | Хашаажуулсан талбай / км/ | 2 ААН, 18 иргэн хувийн хөрөнгө оруулалтаар 720 га буюу 20км тариалангийн талбайг энэ онд хашаажуулсан. | 30 км | Эргэлтэнд орж байгаа 4500 га-талбайг хашаажуулсан байна. |
| | | | Бордсон талбай /га/ | Эрдэс болон шим бордоогоор 8 ААН, 23 иргэн 2390 га тариалангийн талбайг бордсон. | 2000 га –иас доошгүй байна. | ААН, иргэд тарьсан таримлын үрээ 95% ариутгаж тариалалт хийсэн. Октябрь сүмбэр ХХК 400 га-д бууц цацаж талбайгаа бодрдсон. Хэрэгжилт 70% |
| | | 76. Мод бутлаг ургамлын тариалалт, жимс, жимсгэний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна. | Шинээр тариалах талбай /га/ хураах ургац / тн/ | Жимс, жимсгэнэ 1 ААН, 6 иргэн 57,08га-гаас 3,1 тн ургац хураaж авсан. Нийт бутны тоо 71348 бут,үүнээс үр жимсээ өгч байгаа бутны тоо 51348 ширхэг бут үр жимсээ өгч байна. | 60,0 га 18,0 тн | 1700 ширхэг мод, бут шинээр таригдсан Хэрэгжилт 70% |
| | | 77. Хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, шинэ ургацын ногооны хангамжийг нэмэгдүүлнэ. | Зуны хүлэмж /га/ /тн/ | Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэлийн хүрээнд 0,13 га-гаас 23,9 тн ургац хураасан. | 0,5 га-гаас 92тн | 0.13 га-д хүлэмжийн аж ахуй эрхэлж байна. Хэрэгжилт 30% |
| | | 78. Зоорь, агуулахын хэмжээг нэмэгдүүлж, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг тогтвортой хангах нөхцлийг бүрдүүлнэ. | Зоорь агуулахын багтаамж өссөн дүн /ш.тн/ | Зиргэн 5 тн багтаамжтай 5 нүхэн зоорийг төмс, хүнсний ногоо хадгалах зориулалтаар. | 2ш 3650тн | 1000 тн-ын багтаамжтай 2 ширхэг зоорийг засварлаж ашиглалтанд оруулсан. Хэрэгжилт 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 79. Хүнсний ногооны урамшуулалд иргэд, ногоочдын бүлгүүдийг бүрэн хамруулах зорилгоор үе шаттай сургалтыг зохион байгуулна. | Хүнсний ногооны урамшуулалд хамрагдсан иргэдийн тоо | - | Хамрагдсан иргэдийн тоогоор | Хүнсний ногооны урамшуулалд 2 аж ахуй нэгжийг хамруулсан. |
| | | | Сургалтын тоо | - | 2 | Хүнсний ногоо тариалагчдын зөвлөгөөнд 12 хүнийг хамруулсан.<br>Хэрэгжилт 70% |
